



**МОНГОЛЫН САГСАН  
БӨМБӨГИЙН ХОЛБОО НҮТББ**

1016245, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо,

Сүхбаатарын талбай Централ тауэр, 4 давхар, 407А

Утас: +976 77774144, +976 8888 6579

Имэйл: [contact@mongolia.basketball](mailto:contact@mongolia.basketball)

2024.02.10 № 19

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Г 7  
ИНС APES,  
БИШРЭЛТ МЕТАЛЛ  
БАГУУДАД

**“ХАРИУЦЛАГА ТООЦОХ ТУХАЙ”**

Монголын Сагсан Бөмбөгийн Холбооны “Үндэсний дээд лиг”-ийн 2024 оны 2 сарын 9-ний өдрийн “Бишрэлт Металл” – “ИНС Ares” багуудын тоглолтын үеэр болсон асуудлыг хэлэлцээд Монголын Сагсан Бөмбөгийн Холбооны “Үндэсний дээд лиг”-ийн Мэргэжлийн зөвлөлөөс “Үндэсний дээд лиг”-ийн тэмцээнийг зохион байгуулах журмын 3-р зүйлийн 3.8, 5-р зүйлийн 5.1, 5.2, 5.5 дахь хэсгүүдийг тус тус үндэслэн, эсрэг багийн тоглогчийн биед халдсан, хүчирхийллийн хэлбэр бүхий үйлдэл гаргасан, талбай дээрх сөргөлдөөнийг зогсоох, хязгаарлахын оронд дэвэргэсэн, тухайн байдал үүсэх нөхцөлийг бий болгосон болон сэлгээний хэсгээс талбайд зөвшөөрөлгүй орсон, асуудлыг дэвэргэсэн, “Үндэсний дээд лиг”-ийн тэмцээн болон үзэгчдийг илтэд үл хүндэтгэсэн ёс зүйгүй үйлдэл гаргасан тоглогч нарыг зөрчил гаргасанд тооцож, дараах арга хэмжээ авахаар шийдвэрлэв.

**МЭРГЭЖЛИЙН ЗӨВЛӨЛӨӨС ТОГТООХ НЬ:**

1. “Бишрэлт Металл” багийн тоглогч Jeyntal Cylla – г 2 тоглолтонд оролцуулахгүй байхаар;
2. “ИНС Ares” багийн тоглогч Т.Мэндбаярыг 1 тоглолтонд оролцуулахгүй байхаар;
3. “ИНС Ares” багийн тоглогч Ц.Сэргэлэнбаатарыг 200,000 төгрөгөөр торгохоор;
4. “Бишрэлт Металл” багийн тоглогч О.Сайнбаяр, Э.Дөлгөөн, “ИНС Ares” багийн тоглогч С.Эрдэнэдалай нарыг дахин зөрчил гаргахгүй байхыг сануулахаар тус тус тогтоосугай.
5. Мэргэжлийн зөвлөлийн тогтоолын хэрэгжилтийг хангаж, торгуулийг төлүүлэх, тоглолтонд оролцуулахгүй байх арга хэмжээ авахыг Ажлын хэсэгт даалгасугай.

МЭРГЭЖЛИЙН ЗӨВЛӨЛ БОЛОН АЖЛЫН ХЭСЭГ

